



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/91

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 101 дүгээр тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2023 оны 4 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 7 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2024 оны 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 101 дүгээр тушаалын дагуу Хөвсгөл аймагт хуваарилагдсан 225 тн, тэжээлийн будааг тээвэрлэх зардал, будааг савлаж сумдад хүргэх, мөн “Дэлхийн Зөн Монгол” олон улсын байгууллагын “Дулаахан өвөлжье” аянд нэгдэхтэй холбоотой зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлын 38,187,500 (Гучин найман сая нэг зуун наян долоон мянга таван зуу) төгрөгийн зардлыг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА


П.ЛХАГВАЖАВ



671:010283



Аймгийн Засаг даргын 2024 оны  
03 дугаар сарын 01-ны өдрийн 03 дугаар  
захирамжийн хавсралт



ГАМШГИЙН ЭРСДЭЛ БУУРУУЛАХ ЗАРДЛААС  
ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Байгууллагын нэр	Зардлын утга	Хөрөнгийн хэмжээ
1	Иргэн Ц.Энхболд	Тээврийн зардал	19,687,500
2	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Буудай савлахтай холбоотой зардал	8,500,000
3	Дэлхийн Зөн Монгол байгууллага	“Дулаахан өвөлжье” аянд нэгдэх	10,000,000
	Бүгд		38,187,500

-----oOo-----